



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 505

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Дундговь аймгийн Цагаан суварга-Мандах 22 кВ-ын дамжуулах агаарын шугам, Мандах 22/04 кВ-ын дэд станц, Цагаан суварга-Хатанбулаг 35 кВ-ын дамжуулах агаарын шугам, 220/22 кВ-ын Цагаан суварга дэд станцын өргөтгөл, Хатанбулаг 35/10 кВ-ын дэд станцын нийт 9,867,151,452.00 (есөн тэрбум найман зуун жаран долоон сая нэг зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001059

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны дугаар сарын 1-ны өдрийн
5 дүгээр тогтоолын хавсралт

**"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ШИНЭЭР БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ /төг/	Тоо хэмжээ	Хуримтлагдс ан элэгдэл /төг/	Үлдэгдэл өртөг /төг/
1	Цагаансуварга-Мандах 22 кВ-ын 60.6 км цахилгаан дамжуулах агаарын шугам	2015-2016	2,295,273,690.50	1	0	2,295,273,690.50
2	22/0.4 кВ-ын Мандах дэд станц	2015-2016	308,326,309.50	1	0	308,326,309.50
3	"Цагаансуварга" дэд станцын Хатанбулаг гаргалга 22/35 кВ 1600 кВа-ын өсгөх дэд станц	2015-2016	746,846,190.20	1	0	746,846,190.20
4	Цагаансуварга-Хатанбулаг сумын 35 кВ- ын 116.1 км цахилгаан дамжуулах агаарын шугам	2015-2016	5,530,215,040.20	1	0	5,530,215,040.20
5	Хатанбулаг сумын 35/10 кВ-ын станцын ХХБ, 1000кВа-ын дэд станц	2015-2016	721,425,380.20	1	0	721,425,380.20
6	Хатанбулаг сумын төвийн 10 кВ-ын 2.75 км цахилгаан дамжуулах агаарын шугам	2015-2016	138,314,741.20	1	0	138,314,741.20
7	Хатанбулаг сумын төвийн 10/0.4 кВ-ын 160 кВа-ын 3 ширхэг дэд өртөө	2015-2016	126,750,100.20	3	0	126,750,100.20
			9,867,151,452.00	9	-	9,867,151,452.00
Нийт дүн			(есөн тэрбум найман зуун жаран долоон сая нэг зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун тавин хоёр төгрөг)	-	-	(есөн тэрбум найман зуун жаран долоон сая нэг зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун тавин хоёр төгрөг)